



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/24

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 02 дугаар дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02, 04 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын 2021 оны А/53 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Коронавируст /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлж, эрсдлийг бууруулах зорилгоор аймаг, сум хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, худалдаа үйлчилгээ эрхэлдэг хүнс, барааны дэлгүүрүүд, цайны газар, тамхины цэгийн үйл ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 11 ны өдрийн 20:00 цагаас 2021 оны 02 дугаар сарын 15 ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хязгаарласугай.

Хоёр: XVII жарны "Цагаагчин" үхэр жилийн хаврын Тэргүүн сарын шинийн нэгэн, Монголын цагаан сарын баярын үеэр иргэдийг гэртээ зочин урих, айлд зочлохыг, "Шинийн нэг"-ний өглөөний нар харах зорилгоор уул, овоонд гарч бөөгнөрөл үүсгэх, албан байгууллага, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчид болон иргэд, олон нийтийг хамруулсан золголтын арга хэмжээ зохион байгуулахыг тус тус хориглосугай.

Гурав: Монголын цагаан сарын баярыг сумын нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд иргэд, олон нийтээр өргөн тэмдэглэхгүй байж, Коронавируст /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлыг сумын төрийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулахыг төрийн байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4880100081

Дөрөв: Голомтот бүс нутгаас ирсэн иргэд гэрийн ажиглалтад байх хугацаанд гэрээс гарахгүй хорио цээрийн дэглэмийг баримталж, сумын Онцгой комисс, Эрүүл мэндийн төвөөс өгч байгаа заавар зөвлөмжийг дагаж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөхийг тус иргэдэд уриалсугай.

Тав: Баяр, амралтын өдрүүдэд иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, хяналтын постны тоог 3 цэгт нэмэгдүүлж, тухайн өдрүүдэд ажиллах албан хаагчдыг томилон үүрэг, чиглэл өгч гүйцэтгүүлэхийг ЗДТГ, Сургууль, Цэцэрлэгийн дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

Зургаа: Сумын төвийн лагерь хороололд хөдөлгөөнт эргүүл хийх, ард иргэдэд зарлан мэдээлэх, хөдөөгийн малчин иргэдэд хүнс, шатахууныг 2021 оны 02 дугаар сарын 11 ны өдрийн 20,00 цагаас өмнө авах, голомтот бүс нутгаас ирсэн иргэдийн гэрийн хяналтын ажиглалтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүн /Н.Загдхорол/, багийн Засаг дарга нар, цагдаа /Б.Насанжаргал/, ЭМТ-ийн дарга /С.Батцэцэг/ нарт үүрэг болгосугай.

Долоо: Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч /Л.Золжаргал/, СОК-ын Штабын дарга /С.Нарантунгалаг/, Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/ нарт даалгасугай.

ДАРГА



М.БАЯРСҮХ